

Одоогийн монгол ярианы хэлний дүрслэх үг,  
тэдгээрийн хэрэглээ

Алена Оберфалзерова  
(Карлын Их сургууль)

Оршил

Монгол хэлтэн (түүнчлэн түрк, түнгүүс) нэг талаас байгалийн ард түмэн болохоор тэр үү, нөгөө талаас нүүдэл соёлтойн учир уу, хэлэнд нь нэн эртний хүний хэлний олон сонин гайхамшигт үзэгдэл хадгалагдсан юм. Бүхэлд нь хэлбэл хөөрүү яруу үгсийн сан болон хэлзүйн хэлбэрүүд, тодорхой ялган хэлбэл тус бүрдээ өвөрмөц хөөрүү хэрэглүүр болдог „орлуулбар болон орлуулбар хэлц, төлөөлбөр үг ба хэлц, дүрслэх үгс, баймж үгс, хоршоо үгс, баймж санааны хэлзүйн хэлбэрүүд ба баймжийн задлаг загварууд, авианзүйн нэмэлт орлуулбар хэрэглүүрүүд, хөг аялга, давтал зэрэг“<sup>1</sup> болно.

Одоогийн монгол хэлний эдгээр үзэгдэлүүд бол сонирхолтой хэсэг бүлэг үгс төдий биш, тус бүрдээ бүхэл системийг бүрдүүлж байгаа нүүдэлчин ардын өдөр тутмын ярианы хэлний эмотив хэрэглүүр, бараг бүгд судлагчдын анхааралд өртөөгүй байгаа сонин сэдэв байна. Дээр дурдсан үзэгдэлүүдээс зөвхөн баймж үгс, баймжийн задлаг загварууд, хоршоо үгс, холбоо үгс зэрэг сэдвээр судлагчийн бичсэн зарим ажил<sup>2</sup> бий боловч бидний ажлаас<sup>3</sup> бусад нь үндсэндээ бичиг зохиолын хэлний хэлний зүйн чиглэлтэй судалгаа байна.

Монголын нүүдэлчин малчдын дунд бидний явуулж буй хээрийн судалгааны ажил, ярианы хэлний коммуникацийн этнографийн чиглэлтэй<sup>4</sup> болохоор бичиг зохиолын хэлний материалаас өөр байгаа юм. Монгол үндэстэн олон зуун жилийн бичгийн утга зохиолтойг бид мэдэж байна. Гэтэл нүүдэлчин малчидын ердийн ярианы хэлийг ажиглахад бичиг зохиолын

<sup>1</sup> Oberfalzerová, A., 2002, *Metaforická řeč a myšlení mongolských nomádů* (analýza živých rozhovorů) /Metaphorical speech and thought of Mongolian Nomads. Analysis of live interviews/. Ph.D. Dissertation, Charles University, Prague 2002, 217 pp. (докторын зэрэг хамгаалсан зохиол).

<sup>2</sup> Баймжийн талаар Ю. Мөнх-амгалан, *Орчин цагийн монгол хэлний баймжийн ай*, Улаанбаатар 1998, pp. 370; хоршоо үгийн талаар Б. Ринчен, *Монгол бичгийн хэлний зүй, дөтгөөр дэвтэр*, Өгүүлбэрзүй, Улаанбаатар 1967, pp. 125; Grollová, I., *Zdvojení v mongolštině* /Doubling in Mongolian/. M. A. Thesis, Prague 1986. pp 220; холбоо үгийн талаар Б. Рагчаа, *Орчин цагийн монгол хэлний бодит нэрийн холбоо үг*, Улаанбаатар 1975, pp.159.

<sup>3</sup> Зүүлт 1, <sup>4</sup> үзнэ үү.

<sup>4</sup> Oberfalzerová, A., Formal Aspects of Metaphorical Speech. In: *MONGOLICA PRAGENSIA '02, Ethnolinguistics and Sociolinguistics in Synchrony and Diachrony*. Edited by Jaroslav Vacek and Alena Oberfalzerová. Triton, Praha 2002, str. 151-185; Oberfalzerová, A., The Use of Mongolian in the Perspective of Cultural Context. In: *MONGOLICA PRAGENSIA '03*, str. 175-205; Oberfalzerová, A., Language of dreams – one of the keys to the culture of nomads, In: *MONGOLICA PRAGENSIA '04*, p. 11-62; Lubsangdorji, J., Buddhist Lamas and Mongolian. In: *MONGOLICA PRAGENSIA '02*, p. 151-185; Lubsangdorji, J., The phonetics of foreignisms coming through Russian into present-day Mongolian ('mongolization'). In: *MONGOLICA PRAGENSIA '04*, p. 91-112; Lubsangdorji, J., Analytic constructions of modal meaning in Mongolian. In: *MONGOLICA PRAGENSIA '03*, p.175-205. Kapišovská, V., Expressing time in Mongolian. From nomadic tradition to urban life-style. In: *MONGOLICA PRAGENSIA '04*, p. 63-90;

хэлний нөлөө бараг байхгүй. Тэгсэн мөртлөө хурц яруу хэрэглүүрээр дүүрэн байдаг нь их яруу найрагч, зохиолч, бичгийн хүмүүсийн зохиож өгсөн метафорчилал болов уу даа гэмээр байдаг. Тийм метафорчилалын сангаас төлөөлбөр үгс, дүрслэх үгсийн хэрэглээ нь хэл сэтгэлгээний судлалд онцгой анхаарал татна.

### Дүрслэх үг

Юмс үзэгдэл, үйл хөдөлгөөний нүдэнд үзэгдэх, чихэнд сонсогдох, биед хүртэх шинж тэмдэг, дүр байдлыг зураглан үзүүлдэг үгс монгол хэлний үгсийн санд ихээхэн суурийг эзэлнэ. Зарим үгс зөвхөн сонсдох чимээг, зарим нь зөвхөн харагдах байдлыг дүрсэлнэ. Тэдгээр сонин үгсийн амьд хэрэглээг ажиглавал харагдах дүр ба соностох чимээг нэгэн хам болгон дүрслэх нь маш амьдлик байдаг. Тийм яриаг сонсоход агшин зуур кино зураг үзэх мэт болж мэдрэл доргиж сэтгэл хөдөлнө.

Дүрслэх үгийг тусгайлан судалсан өгүүлэл, ном зохиол энэ хир үгүй. Гэвч дүрслэх үгийн хэлзүйд (үгийн язгуурын байрлал, дагаварын утга, үүрэг) холбогдох зарим тэмдэглэл, монгол хэлийг судлагчдын бүтээлд байна.

Дүрслэх үйл үг бүтээгч дагавруудыг монгол хэлний зүйн бүтээлүүдэд „үйл үгийн байдал” гэдэг үйл үгийн категорид багтааж, -схий дагавартай хоромхон үйлдэх байдал, -лз, -гана дагавартай давтан үйлдэх байдал<sup>5</sup> гэж тодорхойлдог.

Гэтэл зарим судлагчид үйл үгийн үндэс үүсгэх бүтээцгүй хэв маяг гэж тодорхойлоод дагавар -ай, дагавар -гана, дагавар -лза<sup>6</sup> гэж дагаврын дүрслэх утгыг анхаарч тайлбарласан юм. Дүрслэх үйл үг бүтээх дагавруудын талаархи дээрхи хоёр үзэл түрк хэлний судлалд бас нэгэн адил байдаг.<sup>7</sup>

Судлагч нарын дотроос дүрслэх үгийн судлалд анхны үгийг хэлсэн хүн бол П. Бямбасүрэн юм. Тэр „янз бүрийн дүр байдлыг маш нарийн заасан, голдуу идэвхигүй язгууртай, бусад үгст бараг тохиолдохгүй тусгай дагаврууд авч шинэ үг бүтээдэг дүрслэх үгс (харагдах дүрслэх үг), дуу чимээ дуурайсан язгууртай бөгөөд түүнээс шинэ үг бүтээх бас тусгай дагавартай дуу чимээний үгс (сонсдох дүрслэх үг) – ийм хоёр янзын үгс байна”<sup>8</sup> гэж оновчтой тайлбар өгөөд ийм хоёр өөр бүлэг үгсийг нэгтгэн дүрслэх үг гэж нэрлэж байгаад эргэлзсэн байна. Миний үзэхэд энэ хоёр бүлэг үгсийн хэлбэржих арга хэдий өөр боловч эмоц дүрслэл гаргах шинжээрээ нэгдэж байгаа болохоор дүрслэх үгс (emotiv words) гэж нэрлэх нь оновчтой биз ээ. П. Бямбасүрэн, бидний дээр дурдсан -ай/ий, -лз, -с, -га, -на (-гана) дагавруудыг „дүр байдлыг заасан үгийн идэвхигүй язгуур дээр ордог морфем”<sup>9</sup> гэж тодорхойлсон нь ч анхаарал татаж байна.

Үүсмэл биш дүрслэх үндэс буюу сонсдох дүрслэх үгс (сэрүүн салхи сэр сэр үлээх, ширүүн бороо шир шир орох гм.) бол монгол хэлийг судлагчийн бүтээлүүдэд „сул үг, дайвар үг, үйл үгийн угтвар, нөхцөлгүй үг гэх зэргээр янз янзаар тайлбарласан”<sup>10</sup> байдаг. Судлагч Ш.Лувсанвандан, Э.Кузьменков нарын бүтээлд үйл үгийн байдал гэх нэрлэлтээс татгалзаж дүрслэх үг<sup>11</sup>, „изобразительные глаголы”<sup>12</sup> гэдэг нэр томъёог нэг удаа дурдаж өнгөрөв. Дүрслэх үгсийг үйл үгийн байдал гэдэг категориос салгахыг оролдсон нь судалгааны шинэ шат болсон гэж би үзнэ. Монгол хэлний коммуникацид маш чухал үүрэг бүхий дүрслэх үгийн судалгааны төлөв байдал иймэрхүү байна.

Одоогийн монгол хэлний дүрслэх үгс бол, хэлзүйн хэлбэрийн талаас үүсмэл, үүсмэл бус гэсэн хоёр анги, үүрэг ба утгазүйн талаас харагдах дүрслэл үг, сонсдох дүрслэл үг гэсэн хоёр

<sup>5</sup> Rita Kullman, Tserenpil, D., 1996, p.135-136.

<sup>6</sup> Грамматика Бурятского языка, 1962, p.180-185.

<sup>7</sup> Уз: Насилов Д.М., Еще раз о виде в тюркских языках. In TUPCOLOGICA, Ленинград 1976, p. 111-120.

<sup>8</sup> Бямбасүрэн П., 1970, p. 277.

<sup>9</sup> Бямбасүрэн П., 1970, p. 279.

<sup>10</sup> Лувсанвандан, Ш., 1968, p.32.

<sup>11</sup> Лувсанвандан, Ш., 1968, p.31.

<sup>12</sup> Кузьменков, Е. А., 1984, p. 83.

анги, өгүүлбэрзүйн талаас задлаг загвар үүсгэх, үг давтах, хорших зэргийн экспрессив хэрэглүүр бүтээх аргуудаар баялаг юм. Түүнээс гадна сонсдох ба харагдах дүрслэлийг нэгэн үгэнд шингээх, түүний утгыг өөр юманд шилжүүлж шинэ метафор бүтээх зэргээр эмотив үгсийн экспрессив чадамжийг нэмэгдүүлэх арга байдаг. Жишээ нь "гүвшу-" гэдэг үйл үг бол сонсдох дүрслэл (хөхөх чимээ гув- гув), харагдах дүрслэл (хулгайгаар хөхөж буй төлийн дүр) хоёул хам байна. Гэтэл "ах дүүү нараа гүвшиж амьдарч байгаа хүн" гэсэн хэллэгт уг үгийн метафор утга гарч байна. Би энэ жижиг өгүүлэлд зөвхөн харагдах дүрслэх үгийн (энэ өгүүлэлд товчоор дүрслэх үг гэж нэрлэв) коммуникатив үүрэг-утгазүйн гол онцлогийг товч тодорхойлохыг оролдсон юм.

### Дүрслэх үгийн авианы дүрс

Монгол хэлний дүрслэх үгс бол байгаль хүн хоёрын анхан цагийн харилцааны дурсгал өнөө үеийг хүртэл хадгалагдсан нь гэж болох биз. Байгалийн юмс ба үзэгдэлүүдийн гаргадаг өнгө дүр, дуу чимээ, хөдөлгөөн, овор байдалын олон зүйл хүний мэдрэхүйд хүртэн авиан дүрсээр хадгалагдаж, авиан дүрсээр илэрсний дурсгал, дүрслэх үгнээс харагдана. Эгшиг, гийгүүлэгч авиа бүр байгалиас ирсэн дуун дүрс юм. Тэдгээр дуун дүрс мэдрэгдэх (харагдах) төдийгүй сэтгэгдэнэ.

Монгол хэлний **а** эгшиг – голдуу хөндлөн чиглэлдхи том, өргөн, бат чийрэг, хүчтэй, сүртэй дүрс ба хөдөлгөөний авиан дүр болно. Ж.: бандаганасан / бандгар шар авгай, ханхар эр, тантай-

**э** эгшиг – голдуу босоо чиглэлдхи том, өргөн боловч хэврэг, сул, сүргүй дүрс ба хөдөлгөөний авиан дүр болно: бэндэгнэсэн / бэндгэр хар авгай, дэлбэгэр чих

**о** эгшиг – голдуу босоо чиглэлдхи бага, богино, нарийн, бат чийрэг, эршүүд: бондогносон / бондгор авгай, гозгор хар хүн, оехой-

**ө** эгшиг – голдуу хөндлөн гадаргуу дээрхи юмуу доорхи босоо чиглэлийн жижиг, богино, хэврэг: бөндөгнөсөн / бөндгөр хүүхэд, хөнхгөр хүн, өөхий-

**у** эгшиг – голдуу босоо гадаргууд хөндлөн чиглэсэн товгор юмуу хонхор, цул, эршүүд: бундайсан / бундгар (царайтай) банди, дургүйцээд тунтганаад

**ү** эгшиг – голдуу хөндлөн гадаргуу дээрхи юмуу доорхи босоо чиглэлдхи эзлэхүүн бүхий товгор, сул, хэврэг, эсвэл босоо гадаргуудхи жижиг, хэврэг, эмзэг төвгөр юмуу хонхор: бүнхийсэн / бүнхэр майхан, бүрзүйсэн / бүрзгэр царай, бүлтийсэн / бүлтгэр (нүдтэй) авгай, цүндгэнэ-

Гийгүүлэгч авианууд бас өөрийн дүрслэх чадварын дагуу дүрслэх үгсийн хувилбаруудыг бүтээнэ. Жишээ нь:

**б:** банхай- (толгойн доод хэсэг өргөн, том, эмоц эвгүй), банхайсан нохой

**бүнхий-** (гэрийн хэлбэртэй өндөрлөг, эмоц сонин хачин), бүнхийсэн сонин байшин

**д:** данхай- (толгойн дээд хэсэг өргөн, том, эмоц эвгүй), данхайсан эр

**дүнхий:** (хагас тойрог хэлбэрт өндөрлөг, эмоц сүртэй), дүнхийсэн хөх уул

**з:** занхай- (хүн, амьтаны эрүү өргөн, том, эмоц эвгүй), занхайсан хүн

**х:** ханхай- (тэгш өргөн, эмоц сүртэй), ханхайсан уул, ханхайсан бөх

**хүнхий:** (хагас тойрог хэлбэрт гүн хонхор, эмоц айдас хүрэм), хүнхийсэн эрэ

Ингээд монгол хэлний дүрслэх үгсийн нэг бүлэг, өөрийн бүтэц дэх эгшиг ба гийгүүлэгчийн дуун дүрсийн дагуу олон хувилбартай болно. Хувилбар тус бүр өвөрмөц дүрслэл<sup>13</sup> ба мэдрэмжийг өгнө.

### Дүрслэх үгийн хэлбэржилт

Дүрслэх үгийн үндэс нь одоогийн хэлэнд биеэ даасан лексик утгагүй, эртний тэмдэг нэр бололтой: **данха-дэнхэ, сагса-сэгсэ, сарва-сэрвэ, сагла-сэглэ, огно-ондо- өндө, оодо-тогдо-могдо, овхо-өвхө...** маягийн үүсмэл үндэс (сэцондару дэривативэ стэм) байна. Ийм

<sup>13</sup> Энэ үзэгдлийг монголын хэл шинжлэлч М. Базаррагчаа монгол хэлний авианы судалгааны номдоо эгшиг ба гийгүүлэгч тус бүрээр нь тодорхой тайлбарласан юм. (Базаррагчаа М., 1987, тал 168, 144 – 177).

үндэс монгол хэлэнд маш олон. Бүтэц нь идэвхигүй язгуур үг<sup>14</sup> + дүрслэх үндэс бүтээх дагавар (CV)<sup>15</sup>. Монгол хэлний бараг бүх гийгүүлэгч ардаа богино эгшиг авч идэвхигүй дүрслэх үндэс бүтээгч дагавар (-ха/хэ/хо/хө, -са/сэ/со/сө, -ва/вэ/во/вө... г.м.) болно гэж би үзэж байна.

### Дүрслэх (харагдах) үг бүтээх дагаварууд

а) **Дүрслэх үйл үг** бүтээх нь:

Дүрслэх үндсэнд дараахи дагаваруудыг залгана.

-и / у<sup>16</sup>, дүрслэх утга ерөнхий, тодорхой: оодой-, тогдой-, овхой-, өвхий-...

-гана (гоно/гэнэ/гөнө)<sup>17</sup>, дүрслэх утга олон удаа үйлдэх: оодгоно-, тогдгоно-, овхгоно-, өвхгөнө- ...

-лза (лзэ/лзээ/лзө)<sup>18</sup>, дүрслэх утга нэг биш удаа: оодолзо-, тогдолзо-, овхолзо-, өвхөлзө-

...

Одоогийн монгол хэлэнд дүрслэх үндсээс харагдах дүрслэх үйл үг бүтээх ийм гурван дагавар байна.

Дүрслэх үйл үндсэнд цааш үйлдүүлэх хэвийн дагавруудыг<sup>19</sup> залгаж шинэ үйл үндсүүдийг бүтээдэг. Үйлдүүлэх хэвд орсон дүрслэх үйл үгсийн дүрслэл нь өгүүлэгч ба сонсогчдод хоёр талдаа илүү амьдлэг, эмотив болдог. Информатор Дуламсүрэнгийн доорхи жижиг ярианд 13 дүрслэх үг гарсны 8 нь үйлдүүлэх хэвээр хэлбэржсэн байна. Энэ нь уг хэлний этнографийн коммуникацид үйлдүүлэх хэв чухал үүрэгтэйг харуулна.

б) **Дүрслэх дайвар үг** бүтээх дагавар:

-га/го, гэ/гө/, -г: (үйлийн эхлэлийн дүрслэл, нэг удаа, түр үйлдэх, хий-, гэ- гэдэг үйл үгийн өмнө тохиолдоно): оодого хий-, тогдого гээд, бандага бандага гээд

-с: (үйлийн голдуу төгсгөлийн дүрслэл, нэг удаа, түр үйлдэх, хий-, гэ- гэдэг үйл үгийн өмнө тохиолдоно): оодос хийгээд, оодос оодос гээд, бандас гээд далд орчлоо

ц) **Дүрслэх тэмдэг нэр** бүтээх дагавар:

-гар/гор/гэр/гөр: оодгор цагаан өмдтэй, нүцгэн шилбээ гялалзуулсан аегай

-н, -аан/ээн/оон/өөн: оодон дээл, оодонгийн бяруу

-аан/ээн/оон/өөн: могдоон хул морь, цүгдээн хээр гүү

д) **Дүрслэх цагт үйл** бүтээх давтамжтай дагавар:

-сан/сон/сэн/сөн<sup>20</sup>: шовойсон шовойсон хөшөөнүүд

ф) **Дүрслэх жинхэнэ нэр** бүтээх дагавар:

-ай4, -аа<sup>4</sup>, -аахай4, -аадай4, -уулай2: Өөхөн бөмбий /бөмбүүлэй /

бөмбөөдэй, Араг сагсай /сагсаахай / сагсаадай

<sup>14</sup> Акад. Ш. Лувсанвандан одоогийн монгол хэлний язгуурыг идэвхитэй (нөхцөл шууд авч чадах), идэвхигүй (нөхцөл шууд авч чадахгүй, дагавар авсны дараа сая нөхцөл авна) гэж хоёр ангилаад 54 тийм идэвхигүй язгуурыг тодорхойлсны дотор дүрслэх үгийн үндэс гэж миний нэрлэж буй зүйл багтаж байна. Үз Ш. Лувсанвандан, 1968, р. 104-119.

<sup>15</sup> CV: C (Consonant), V (Vocal).

<sup>16</sup> Одоогийн монголын орос бичигт -ай/ой/ий.

<sup>17</sup> Одоогийн монголын орос бичигт -гана4.

<sup>18</sup> Одоогийн монголын орос бичигт -лз.

<sup>19</sup> Монгол хэлний үйлдүүлэх хэвийн дагавруудаас дүрслэх үйл үгэнд дагадаг нь -лга /лго/лгэ/лгө (урт ба хос эгшгээр төгссөн үгэнд), -уул/үүл (богино эгшгээр төгссөн үгэнд) – энэ хоёр юм. Бусад дагаврууд дүрслэх үйл үгэнд дагахгүй. Үүний учир нь дүрслэх үйл үг гийгүүлэгчээр төгсдөггүй!

<sup>20</sup> Энэ -сан4 бол угтаа үйлт нэрийн өнгөрсон цагийн нөхцөл боловч, ярианы хэлний хэрэглээнд цагийн утга алдаж тэмдэг нэрийн үүрэгээр нэрийн холбоо үгэнд тодотгол болох нь ихээхэн давтамжтай юм. Үйлт нэрийн бусад дагаврууд дүрслэх тодотгол байж болох боловч ярианы хэлэнд давтамжтай биш болно.

## ИШИЛСЭН НОМ ЗҮЙ

- Базаррагчаа, М., 1987, Монгол хэлний авиа сэлгэх ёс, Улаанбаатар.  
Лувсанвандан, Ш., 1968, Орчин цагийн монгол хэлний бүтэц, Улаанбаатар, pp.192.  
Rita Kullman, Tserenpil, D, 1996, Mongolian Grammar, Hong Kong, pp.448.  
Грамматика Бурятского языка, 1962, Институт языкознания АН СССР, Москва, pp.340.  
Кузьменков, Е.А., 1984, Глагол в монгольском языке, Ленинград, pp.138.  
Бямбасүрэн, П., 1970, Орчин цагийн тонгол хэлний үйл үгийн хэв, байдал. In: Studia linguae et litterarum, Insituti linguae et litterarum Academiae scientiarum Reipublicae Populi Mongolici, Tomus VIII, Хэл зохиолын судлал, Улаанбаатар, p. 201-300.

## ӨГҮҮЛЛИЙН ДАГАЛТ

### 1. Хээрийн судалгааны материалаас

Г. Дуламсүрэн, халх, эр, нас 60, боловсрол бага, малчин.  
(Архангай Цэцэрлэг сум, Чулуут баг, 2000 он)

Дуламсүрэнгээс зүүдний тухай сэдвээр сонин яриа аваад цаг дуусах тийшээ хандаж байтал санамсаргүй монгол хэлний нэг маш сонин үзэгдэл рүү шилжин оров. Дуламсүрэн гуай дээш гэрийн унь өөд харснаа "Оройн нар **оодойж** байна. Хөгшин нь одоо мордоод **тогдойлгочихно** оо!" гэв. А.О.:

- Та ямар гоё дүрсэлж хэлэв! Оодойж, тогдойлгочихно гэсэн үгээ тайлбарлаж өгөхгүй юү? Дуламсүрэн гуай, уинд байгаа гэрийн нарыг заагаад:

- Харахгүй юу. Нар унь өөд авираад унаганы сүүл шиг богинохон оодгор юм үлдсэн байгаа биз дээ? Тэнгэрийн нар хэвийгээд оройн сэрүү орж байна гэсэн үг. Тогдойлгоно гэдэг нь болохоор бас нэг оодгор богино биетэй Дуламсүрэн гуай нь мориндоо мордоод пөг пөг шогшуулахад морины нуруун дээр нэг хөрөөдсөн түлээ шиг юм шовойж тогдойгоод инээд хүрмээр ч юм шиг, өрөвдөс хүрмээр ч юм шиг дүр харагдана биз дээ? Тогдойлгоно гэдэг ч наргианы үг юм даа. А.О.:
- Тогдойлго- гэдэг үгний оронд өөр ямар дүрслэх үг хэлж болох вэ? Ду.:
- Би одоо жартай хүн. Нуруу цэх. Морин дээр эрхбиш тогдойж харагдана биз. Нас дал гарахад „мордоод **овхойлгоно**” гэх байх даа. Тэгээд ная гарсан хойно бол "мордоод **өвхийлгөчихнө** дөө" л гэх болно биз дээ, амид мэнд байж байвал (инээв). А.О.:
- Бүр залуу эр хүнийг бол мордоод яана гэх вэ? Ду.:
- Залуу эрс ч мордоод **гялс, жирийлгөчихнэ**. А.О.:
- Эмэгтэйчүүд бол мордоод яах вэ? Ду.:
- Залуу хүүхнүүд бол мордоод **гунхчихна** биз дээ. Авгайчуул бол за одоо хоёулаа мордоод **ганхуулчхая** гэх байх. Нарийн гозгор бүсгүйчүүлийг бол мордоод **жомбойлгочихлоо** гэх байх, өөрийгөө ч эгч нь одоо мордоод **жомбойлгочихно** оо гэнэ (инээв). А.О.:
- Бүдүүн авгайг бол яна гэх вэ? Ду.(инээгээд):
- Гэдэс нь бүдүүнийг бол мордоод **цүндэгнүүлчихлээ** гэнэ биз. Бөгс нь бүдүүнийг бол мордоод **бандагануулчихлаа, бандайчихлаа, тантайчихлаа** гэх биз. Гэхдээ авгайчуул ийм үгийг өөр дээрээ хэлэхгүй, хэлбэл уурлана шүү.

### 2. Аман зохиолоос авсан зарим жишээ

(Нүүдэлчдийн аман зохиолын олон төрөлд дүрслэх үгийг өргөн хэрэглэнэ. Ялангуяа ардын сурган хүмүүжүүлэх зүйн ухааны экспресив, метафор сэтгэлгээний чухал хэрэглүүр – ардын оньсгод дүрслэх үг тун элбэг байгаа нь учиртай байна.)

- **Оодон мориор давхихад туйлсан болж үзэгдэх, үг мэдэхгүй хүнд үг хэлэхэд уурласан болж үзэгдэх** (цэцэн үг).

- Үүлээ хөөсөн тэнгэр нэг **цэмцгэр**  
Үнсээ гаргасан тулга нэг **цэмцгэр**  
Үсээ самнасан авгай нэг **цэмцгэр** (ертөнцийн гурван цэмцгэр)

- Өөхөн **бөмбий**

Араг **сэгсий** (оньсого: хонь)

- Хүн үзээд **гоохолзоно**

Хүзүү сээр нь **нахилзана**

Бараа хараад **бархирна**

Баруун хөл нь **тахилзана** (оньсого: тогоруу)

Гэрийн хойно **гэдэн годон** (оньсого: гээг)

Аав нь **янхир**

Ээж нь **цүзгэр**

Хүү нь **гувшгаа**

Хүүхэн нь **чимхээч** (оньсого : тулга, тогоо, шанага, галын хайч)

Өвөлжөөний замаар **өөвөнхөн өөвөнхөн**

Өтөлсөнөө мэдэхгүй **сээвэнхэн сээвэнхэн**

Хаваржааны замаар **хайванхан хайванхан**

Харьсанаа мэдэхгүй **жууманхан жууманхан** (ардын дуу)